



СЭЛЭНГЭ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/05

Цагаантолгой

Хариуцлагатай жижүүр ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.10, 66 дугаар зүйлийн 66.1, заалт, аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 02/98 тоот албан бичиг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын дагуу 2022 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдөр хүртэлх өдрүүдэд сумын хэмжээнд нийгмийн дэг журмыг сахиулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах зорилгоор ажиллах ажлын хэсэг болон хариуцлагатай эргүүлүүдийг томилон ажиллуулсугай.

2. Хариуцлагатай эргүүлийн ажиллах хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Суманд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хариуцлагатай жижүүр ажиллуулах, цахилгаан, дулаан, цэвэр бохир усан хангамжид саатал гарсан тохиолдолд сумын удирдлагуудад мэдэгдэж ажиллахыг хариуцлагатай эргүүл жижүүрүүдэд даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.



С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: А. Огир-  
Хянасан: С. Шинжирдаг.  
Хувь: 2.

Сумын Засаг Даргын  
20<sup>22</sup> оны 01 сарын 31-ны  
өдрийн 1/05 тоот захирамжийн  
хавсралт №01

Хариуцлагатай эргүүл, жижүүрийн хуваарь

2022.02.02-ны өдөр- Б.Мөнх-Эрдэнэ- (Засаг даргын орлогч)

А.Батдорж-(БОХУБ )

2022.02.03-ны өдөр- Л.Сэлэнгэсайхан-(Ивэн багийн Засаг дарга)

Г.Ганжолоо-(Ивэн багийн байгаль хамгаалагч)

2022.02.04-ны өдөр- А.Одхүү-(ЗДТГ-ын дарга)

Б.Туяасайхан-(ИТХ-ын нарийн бичгийн дарга)

2022.02.05-ны өдөр-Б.Золбаяр- (Хушаат багийн Засаг дарга)

Л.Хүрэлмаа-(1-р цэцэрлэгийн эрхлэгч)

2022.02.06-ны өдөр- Д.Баярсүрэн-(Соёлын төвийн эрхлэгч)

Ч.Төгсбаатар-(Хушаат багийн байгаль хамгаалагч)

2022.02.07-ны өдөр- Д.Өлзийбадрах-(ЕБС-ийн захирал)

Д.Бямбасүрэн-(Санхүүгийн албаны даргын үүргийг түр  
орлон гүйцэтгэгч)